

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Агуулга

Агуулга.....	1
1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга	8
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	9
2.12. Шилэн дансны мэдээлэл	9
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	10
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	10
3. Менежментийн захидал.....	11
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан	15
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	16
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	17
4.5 Зорилтот түвшин, гүйцэтгэл.....	18
5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	19

Товчилсон үгийн жагсаалт

СТОУС	Санхүүгийн тайлангийн олон улсын стандарт
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

Б А Р У У Н БҮСИЙН ЭРЧИМ
ХҮЧНИЙ СИСТЕМ ТӨХК-ИЙН
ЗАХИРАЛ Р.НЯМТУУЛ ТАНАА

2020.03.13 № 06/819
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, 18.5 Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулга дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус нэгтгэсэн санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу, тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын болон Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн, санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус компанийн гүйцэтгэх захирал Р.Нямтуул танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлд тусгасан өр төлбөрийн үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулах, борлуулсан бүтээгдэхүүний өртгийг зөв тодорхойлж бүртгэх талаар зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланд аудит хийлээ.

2019 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох стандартад нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК удирдлага нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг НББОУС, СТОУС болон холбогдох бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Харин тухайн жилийн санхүүгийн нэгтгэсэн тайланг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 01 дүгээр сарын 06-ны өдрөөс 2020 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 03 дугаар сарын 16-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн захиралд хүргүүлэхээр төлөвлөн, Далайван Аудит ХХК-ийн захирал Ц.Жигдэн хянан удирдаж, чанарын хяналтын менежер М.Болормаа, аудитор Ц.Ганболд, аудиторовын туслах Э.Төгөлдөр, Н.Энхцэцэг нар хэрэгжүүлэв.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн тайланг Далайван Аудит ХХК-нд 2020 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн 97 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК эрхэм зорилгоо Байгальд ээлтэй экологийн сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрийг нэмэгдүүлэх, хэрэглэгчдийг эрчим хүчээр тасралтгүй хангах зорилготой гэж тодорхойлсон байна.

Дотоодын эрчим хүчний эх үүсвэрээр баруун бүс нутгийг хангах, цахилгаан дамжуулах төвийн бүсийн системтэй зэрэгцэн ажиллах нэгдсэн системд шилжихэд оршино.

Тайлант хугацаанд компанийн санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”;
- Сангийн сайдын 2019 оны 131 дүгээр тушаалаар батлагдсан “Тендерт оролцогчдоос ирүүлсэн гомдлыг хянан шийдвэрлэх журам”;
- Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”;
- Зам тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дүгээр тушаалаар батлагдсан “Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын жишиг норм”-ыг 1 дүгээр, “Автомашинны 100 км гүйлтэд зарцуулах шатахуун зарцуулалтын үндсэн нормыг нэмэгдүүлэх болон бууруулах нөхцөлүүд”-ийг 2 дугаар, “Автомашинны шатахуун зарцуулалтын нормыг тооцоолох аргачлал, зөвлөмж, жишээ”-г 3 дугаар, “Автомашинны эдэлгээний нөөцийн доод хязгаар буюу гүйлтийн норм”-ыг 4 дүгээр, “Автомашинны сэлбэг хэрэгслийн эдэлгээний доод хязгаарын норм”-ыг 5 дугаар хавсралтаар баталсан;
- Нийгмийн даатгалын тухай хуулиар ажил олгогч болон даатгуулагчаас төлөх шимтгэлийн хувийг 0.5 хувиар нэмэгдүүлсэн;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд заасан хөнгөлөгдөх татварын хэмжээг татвар ногдуулах орлогын хувь хэмжээнээс хамаарч өөрчлөлт орсон;
- Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 407, 408, 409, 410 тоот тогтоолоор Увс ЦТС ХХК, Ховд ЦТС ХХК, Дөргөний УЦС ХХК, Баян-Өлгий аймгийн “Цахилгаан шугам сүлжээ” ОНӨААТҮГ-ын цахилгаан түгээх үйлчилгээний төлбөр болон “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-иас худалдан авах цахилгааны тарифыг шинэчлэн баталсан;
- Эрчим хүчний зохицуулах хорооны 2019 оны 99 тоот тогтоолоор Уул уурхайн аж ахуйн нэгж 151.60 төгрөг, айл өрх 89.80 төгрөг, бусад үйлдвэр аж ахуйн нэгж байгууллага 127.20 төгрөг, айл өрхийн сарын суурь тарифыг 2000 төгрөгөөр шинэчлэн баталсан байна.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь санхүүгийн нэгтгэсэн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Апекс” программ хангамж ашигладаг байна.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “бага” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй байна.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн бэлтгэсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 3 чиглэлд 5 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг бага гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосон нь, аудитын эрсдлийг тодорхойлохдоо өртөг бүрдүүлэлт, зардлын ангилал буруу байх, зардлыг илүү, дутуу бүртгэснээс үр дүн, зорилтод түвшний үзүүлэлт буруу илэрхийлэгдэж болзошгүй тул зардлыг суурь үзүүлэлт болгон сонгосон. Мөн өмнөх жилийн аудитаар илрүүлсэн эрсдэл, өгсөн зөвлөмжийг харгалзан үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг шинжтэй зүйлс илрээгүй ба эрсдэл бага гэж үзэж гурав дугаар улиралын орлогын дэлгэрэнгүй тайлангийн нийт зардлын 2 хувиар тооцож, материаллаг байдлын түвшнийг урьдчилсан байдлаар 422.9 сая төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 32,519.3 сая төгрөгөөс 2 хувиар тооцон материаллаг байдлын түвшнийг 650.4 сая төгрөгөөр тодорхойлж, баталгаажууллаа.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 552.3 сая төгрөгөөр буюу 0.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс авлага, урьдчилж төлсөн зардал /тооцоо, үндсэн хөрөнгө, дуусаагүй барилгын дансны үлдэгдэл өссөн бол мөнгөн хөрөнгө, бараа материалын үлдэгдэл буурсан байна. Харин өр төлбөр ба цэвэр хөрөнгийн өмчийн дүнгийн гол өөрчлөлтөд өр төлбөрийн өсөлт болон эздийн өмч, өмчийн бусад хэсэг өссөн нь гол нөлөөлөл болсон байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөг/
			Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	386.7	309.9	(76.8)
Авлага	1,611.3	1,802.3	191.0
Урьдчилж төлсөн зардал/тооцоо	148.2	650.8	502.6
Бараа материал	1,073.1	1,068.0	(5.1)
Үндсэн хөрөнгө	111,495.9	114,424.1	2,928.2
Хуримтлагдсан элэгдэл	(33,276.3)	(36,843.6)	(3,567.3)
Биет бус хөрөнгө	2,281.2	2,358.4	77.2
Хуримтлагдсан элэгдэл	(52.1)	(91.5)	(39.4)
Дуусаагүй барилга	-	541.9	541.9
Нийт хөрөнгө	83,668.0	84,220.3	552.3
Өр төлбөр	44,071.2	49,222.3	5,151.1
Эздийн өмч	53,761.6	54,068.0	306.4
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,763.6	5,763.6	-

Эздийн өмчийн бусад хэсэг	2,058.3	3,303.4	1,245.1
Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(21,986.8)	(28,137.1)	(6,150.3)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	83,667.9	84,220.2	552.3

Тайлант онд авлага дансны үлдэгдэл 191.0 сая төгрөгөөр өссөн нь “Бадамлах дөл” ХХК, “Шинэ Дулааны станц” ХХК-иас авах цахилгаан эрчим хүчний авлагын үлдэгдэл өссөн нь гол нөлөөлөл болсон байна. Тус авлага өсөх гол шалтгаан нь айл өрх, албаны газрын цахилгаан эрчим хүчний үнэ тариф нэмэгдсэнтэй холбоотой байна.

Авлагын үлдэгдлийн 1,709.1 сая төгрөг нь айл өрх, албан байгууллагуудаас авах цахилгаан эрчим хүчний авлага, 24.9 сая төгрөг тарифын хөнгөлөлтийн авлага, 5.5 сая төгрөг нь татвар шимтгэлийн авлага, 62.8 сая төгрөг нь бусад авлага байна.

Урьдчилж төлсөн зардал/ тооцоо дансны үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 502.6 сая төгрөгөөр өссөн байна. Тус дансны өсөлтөд 2019 оны 10 сарын 02-ны өдөр ББЭХС/201907162 тоот “Ажил үйлчилгээ худалдан авах тухай гэрээ”-г “Хос Ханхөхий” ХХК-тай байгуулж 110/35/10 кВт-ын Улаангом дэд станцаас Өмнөговь хүртэлх 110 кВт-ын цахилгаан дамжуулах агаарын шугамын тулгууруудыг хүчитгэх ажлын төлбөрт 774.4 сая төгрөгийг шилжүүлж урьдчилгаа төлбөрөөр бүртгэсэн нь нөлөөлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх оны мөн үеэс 2,928.2 сая төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн өсөлтөд 2019 онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу бэлтгэсэн хөрөнгө болон Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 564, 560, 538, 455, 433, 274 тоот тус тус тогтоолын дагуу 1,551.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө балансад балансад шилжүүлэн авч бүртгэсэн нь гол нөлөөлөл болсон байна.

Сангийн Яам, Эрчим хүчний Яам ба Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн хооронд байгуулсан 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн “Дамжуулан зээлдүүлэх 6102 MN” тоот гэрээг баталсан. “Эрчим хүчний төсөл 2” төслийн гэрээгээр 12.6 сая ам.доллартой тэнцэх зээлийг дамжуулан зээлдүүлж, зээлийн үр дүнд Увс аймгийн Мянгад суманд 10 мВт хүчин чадалтай Нарны цахилгаан станц барих, мөн дэд станц шинэчлэгдэж Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК хүлээн авахаар болсон байна. Энэхүү “Эрчим хүчний төсөл 2” төслийг хэрэгжүүлэгч нэгж нь 2018 онд байгуулагдсан ба 2019 оноос төсөл хэрэгжүүлэгч нэгж дээр гарсан 541.9 сая төгрөгийн зардлыг дуусаагүй барилга дансанд хуримтлуулан бүртгэсэн нь өсөлтөд нөлөөлжээ.

Нийт өр төлбөр өмнөх оноос 5,151.1 сая төгрөгөөр өссөн. Өр төлбөрийн өсөлтөд Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 287 дугаар тогтоолоор Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-с Оросын Холбооны Улсад төлөх цахилгаан эрчим хүчний төлбөр болох 4,900.0 сая төгрөгийг Төвийн бүсийн нэгдсэн сүлжээний “Нэг худалдан авагчтай загвар”-т хамруулан зохицуулалт хийж барагдуулах шийдвэр гарсан. Тус шийдвэрийн дагуу Диспетчерийн Үндэсний Төв ХХК нь 2019 оны 8 дугаар сарын 16-ны өдөр Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн Оросын Холбооны Улсад төлөх цахилгаан эрчим хүчний төлбөрийг төлсөн тул Диспетчерийн Үндэсний Төв ХХК-нд төлөх өр төлбөрөөр бүртгэсэн нь гол нөлөөлөл болжээ.

“Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн нэгтгэсэн санхүүгийн тайланд Сангийн Яам, Эрчим хүчний Яам ба Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн хооронд байгуулсан 2017 оны “Дамжуулан зээлдүүлэх 6102 MN” тоот гэрээний дагуу 541.9 сая төгрөг, Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн охин компаниуд болон Сангийн Яамны хооронд 2012 онд байгуулсан “Зээлийн хөрөнгийг дамжуулан зээлдүүлэх” 190,133,134 дүгээр гэрээнүүдийн дагуу 35,737.4 сая төгрөгийн урт хугацаат зээлийн өр төлбөр төлөхөөр бүртгэл тайланд тус тус тусгасан байна. Компаниуд алдагдалтай ажиллаж байгаа тул уг урт хугацаат өр төлбөрийг одоогоор төлж барагдуулаагүй байна.

Тус урт хугацаат өр төлбөртэй холбоотой мэдээллийг дараах хүснэгтээр нэгтгэж харуулав.

/ сая төгрөг/

№	Зээлдэгч	Гэрээ байгуулсан огноо	Зээл төлөх сүүлийн хугацаа	Бүртгэгдсэн зээлийн дүн	Хүүний өр
1	ББЭХС ТӨХК	2017.12.25	2035.12.25	541.9	0.0
2	Дөргөний усан цахилгаан станц ХХК	2012.12.27	2026.04.01	31,940.8	3,589.2
3	Ховд Цахилгаан Түгээх Сүлжээ ХХК	2012.09.10	2026.04.01	1,752.6	209.8
4	Увс Цахилгаан Түгээх Сүлжээ ХХК	2012.09.10	2026.04.01	2,044.0	206.4
Нийт				36,279.3	4,005.4

Эздийн өмч ба өмчийн бусад хэсэг дансны үлдэгдэл өмнөх оноос нийт 1,551.5 сая төгрөгөөр өссөн байна. Өсөлтийн гол нөлөөлөл нь ТӨБЗГ-ын 2019 оны 564, 560, 538, 455, 433, 274 тоот тус тус тогтоолын дагуу 1,551.5 сая төгрөгийн үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэн авч бүртгэсэн нь гол нөлөөлөл болсон байна.

2.9. Зорилтот түвшин, гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК-ийн 2019 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Эрчим хүчний сайдын 2019 оны 1 дүгээр сарын 08-ны өдрийн 21 тоот тушаалаар 24,176.4 сая төгрөгийн орлого, 30,077.3 сая төгрөгийн зардалтай, 5,900.9 сая төгрөгийн алдагдалтай ажиллахаар баталсан байна.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь тайлант онд 31,513.5 сая төгрөгийн нийт орлого олж, 37,380.9 сая төгрөгийн зардал гарган, 5,867.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Орлогын давалт нь борлуулсан цахилгаан эрчим хүч төлөвлөгөөнөөс 12.5 сая кВт-аар нэмэгдсэн нь нөлөөлсөн бол зардлыг хэтрүүлэн зарцуулсан нь Эрчим Хүчний Зохицуулах Хорооноос үнэ тариф, чадлын тариф буюу түгээх компаниудад төлж байгаа түгээх үйлчилгээний хөлсийг 2019 онд өсгөж баталсантай холбоотой байна. Мөн 2019 оны төлөвлөгөөнд ОХУ-аас худалдан авах импортын үнийг 2.97 рублиэр тооцсон боловч 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 3.15 рубль болж нэмэгдсэн нь нөлөөлжээ.

Алдагдалтай ажилласан нь түгээх компаниуд болон ОХУ-д төлж байгаа цахилгааны төлбөр, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардал өссөн, мөн урт хугацаат зээлийн хүүний зардал нэмэгдсэн зэрэг нөлөөлсөн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд 5 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 4 эрсдэл тодорхойлж нийт 9 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 445.9 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 372.8 сая төгрөгийн 6 алдааг залруулж, 73.1 сая төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

Аудитын явцад санхүүгийн тайланд дараах залруулгуудыг хийв. Үүнд:

- Илүү төлөлт хийсэн хэрэглэгчдийн 4.9 сая төгрөгийг урьдчилж орсон орлогоор бүртгээгүй, харин сөрөг утгатай авлага бүртгэж нийт авлага болон урьдчилж орсон орлогыг тус дүнгээр дутуу илэрхийлсэн нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 14-ний 361 дүгээр тушаалаар батлагдсан "Аж ахуй нэгжийн санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар"-ын 2 дугаар бүлгийн 8-д "Бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ үзүүлэхээс өмнө тэдгээрийн үнийг худалдан авагч эсхүл захиалагчаас урьдчилан хүлээн авсан тохиолдолд хүлээн авсан мөнгөний хэмжээгээр богино хугацаат өр үүсгэж "Урьдчилж орсон орлого" дансанд бүртгэнэ. Энэ дансыг бараа, үйлчилгээ үзүүлсэн буюу орлого хэрэгжсэн үед

дебитлэж, холбогдох борлуулалтын орлогын дансыг кредитлэнэ.” гэсэн заалттай нийцээгүй;

- Үндсэн хөрөнгийн худалдан авалтад төлсөн 13.1 сая төгрөгийн нэмэгдсэн өртгийн албан татварыг үндсэн хөрөнгийн өртөгт оруулаагүй, нэмэгдсэн өртгийн албан татварын өр төлбөрийг бууруулж тайлагнасан нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 7 дугаар бүлгийн 14.1.5-т “үндсэн хөрөнгө бэлтгэхэд зориулж импортоор оруулсан буюу худалдан авсан бараа, ажил, үйлчилгээнд төлсөн болон үндсэн хөрөнгө худалдан авахад төлсөн албан татварыг хасахгүй.” гэсэн заалттай нийцээгүй;

- Интер РАО ХХК-иас худалдан авсан цахилгаан эрчим хүчний төлбөрт төлөх өр төлбөр болон өртгийг 23.0 сая төгрөгөөр илүү бүртгэсэн нь эрх үүрэг, тодруулга ба толилуулга, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 2 дугаар бүлэг “5.1.4.үнэн зөв байх;” гэсэн заалттай нийцээгүй;

- Хойшлогдсон татварын өр төлбөрийг 280.9 сая төгрөгөөр зөрүүтэй бүртгэсэн нь эрх үүрэг, тодруулга ба толилуулга, үнэлгээ ба хуваарилалт гэсэн батламж мэдэгдлүүдийг хангаагүй, НББОУС-12 “орлогын албан татвар”, Сангийн сайдын 2010 оны 121 дүгээр тушаалаар батлагдсан “татварын өмнөх ашгаас татвар ногдуулах орлогыг тодорхойлох, үүсэх зөрүүг зохицуулах, нягтлан бодох бүртгэлд бүртгэл аргачлал”, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг “Үндсэн хөрөнгийн бүртгэлийн бодлого”-ыг мөрдөөгүй;

- Бараа материалын борлуулалтын орлогыг 3.0 сая төгрөгөөр дутуу бүртгэсэн нь иж бүрэн, тохиолдсон байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна СТОУС-15 “Худалдан авагчтай байгуулсан гэрээний орлого”-ын 9-д (а) гэрээний оролцогч талууд тухайн гэрээг бичгээр, амаар эсвэл бизнесийн хэвшин тогтсон бусад практикийн дагуу хүлээн зөвшөөрсөн бөгөөд өөрсдийн тус тусын үүргийг биелүүлэх хариуцлага хүлээсэн, (д) худалдан авагчид нийлүүлсэн бараа, үйлчилгээнийхээ хариуд авах эрхтэй болсон төлбөрийг тухайн аж ахуйн нэгж нь цуглуулан авах нийлээд их магадлалтай байх гэсэн шалгуур хангагдсан тохиолдолд орлогоор тайлагнана гэж заасныг зөрчсөн;

- Үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 47.9 сая төгрөгөөр дутуу тооцож тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн заалттай нийцээгүй байна.

Залруулагдаагүй 73.1 сая төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Сангийн яам, Эрчим хүчний яам ба Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн хооронд байгуулсан 2017 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн “Дамжуулан зээлдүүлэх 6102 MN”-г тоот гэрээг баталсаны дагуу “Эрчим хүчний төсөл 2” гэрээгээр 12.6 сая ам.доллартой тэнцэх зээлийг дамжуулан зээлдүүлж, зээлийн үр дүнд Увс аймгийн Мянгад суманд 10 мВт хүчин чадалтай Нарны цахилгаан станц барих, мөн дэд станц шинэчлэгдэж Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК хүлээн авахаар болсон байна. Энэхүү “Эрчим хүчний төсөл 2” төслийг хэрэгжүүлэгч нэгж нь 2018 онд байгуулагдсан ба 2019 оноос “Эрчим хүчний төсөл 2”-ийн үйл ажиллагаа явагдаж эхэлсэн. Тус зээлтэй холбоотой бүртгэл хөтлөлт, төслийн нэгжээс хуваарилагдаж ирсэн тооцоог хянах, төслийн нэгж болон холбогдох яамдуудтай тооцоо нийлэх, зээлийн гэрээний нөхцөл, зээл, зээлийн хүүгийн эргэн төлөлтийн талаар анхаарал хандуулах шаардлагатай.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй ба мэдээллийг хугацаанд нь байршуулсан байна.

Шилэн дансны нэгдсэн <https://info.shilendans.gov.mn/login> цахим хуудсанд нийт 5 төрлийн мэдээллийг оруулсан байна. Тухайлбал: 2019 оны худалдан авах ажиллагааны

төлөвлөгөө гүйцэтгэл, батлагдсан төсөв, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл, Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр зэрэг оруулах шаардлагатай нийт 248 мэдээлэл оруулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 30.0 сая төгрөгийн зөвлөмж, 194.1 сая төгрөгийн зөрчилд хүргүүлсэн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Залруулагдаагүй 73.1 сая төгрөгийн алдаа, зөрчлийн дүн бидний тогтоосон 650.4 сая төгрөгийн материаллаг байдлын түвшнээс бага байгаа тул зөрчилгүй санал дүгнэлт өгч байна.

Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн байдлын тайлан, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн стандарт болон холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагааг, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Өр төлбөрийн талаар:

3.1.1 Илрүүлэлт: "Эрчим хүчний хөгжлийн төв" ТӨҮГ-т төлөх 35.0 сая төгрөг, "Бөх мөрөн сумын хийн цахилгаан станц" ХХК-д төлөх 3.1 сая төгрөг, Шинэ нисэх буудлын "Ашиглалтын өмнөх захиргаа"-д төлөх 1.5 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна. Эдгээр нь 2004-2009 онд үүссэн боловч одоог хүртэл төлж барагдуулаагүй, төлөх эсэх нь тодорхойгүй, тооцоо нийлээгүй байгаа нь "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцож байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл: Өр төлбөр барагдахгүйгээс насжилт ихсэх, бодит үнэ цэнээр бүртгэгдэхгүй байх.

3.1.3 Өгсөн зөвлөмж: Өр төлбөрийг тооцоо нийлж баталгаажуулах, үлдэгдлийг төлж барагдуулах эсвэл холбогдох баримт материалыг үндэслэн залруулга хийж бүртгэх.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

3.2 Зардлын талаар:

3.2.1 Илрүүлэлт: Ажилчдад олгосон нүүрсний хөнгөлөлт болон нэг удаагийн шинжтэй тэтгэмж 33.5 сая төгрөгийг борлуулсан бүтээгдэхүүний өртөгт шингээсэн нь "толилуулга ба тодруулга" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 2.6.9-д "өртөг, зардлын бүртгэлийн бодлого"-ыг мөрдөж ажиллаагүй байна.

3.2.2 Эрсдэл: Орлогын дэлгэрэнгүй тайлангийн зардлын ангилал буруу илэрхийлэгдэх;

3.2.3 Өгсөн зөвлөмж: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж ажиллах.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/			
Дансны код	Балансын үзүүлэлт	2018 оны 12 дугаар сарын 31	2019 оны 12 дугаар сарын 31
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	386,717,238.66	309,949,225.12
1.1.2	Дансны авлага	1,550,408,139.94	1,733,976,962.64
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага	1,383,434.13	5,576,733.79
1.1.4	Бусад авлага	59,500,371.51	62,762,647.67
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.6	Бараа материал	1,073,114,115.41	1,067,984,187.79
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	148,192,083.50	650,799,862.56
1.1.8	Дуусаагүй барилга		541,914,435.62
1.1.9	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)	0.00	0.00
1.1.10			
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	3,219,315,383.15	4,372,964,055.19
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	78,219,553,802.36	77,580,405,603.26
1.2.2	Биет бус хөрөнгө	2,229,057,836.89	2,266,876,611.18
1.2.3	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.7	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.5	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	0.00	0.00
1.2.6	Хойшлогдсон татварын хөрөнгө	0.00	0.00
1.2.9			
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	80,448,611,639.25	79,847,282,214.44
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	83,667,927,022.40	84,220,246,269.63
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	Өр төлбөр		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	2,978,303,871.98	3,348,052,175.25
2.1.1.2	Цалингийн өглөг	10,560,716.26	8,175,793.51
2.1.1.3	Татварын өр	1,379,791,124.23	243,342,736.49
2.1.1.4	НДШ-ийн өглөг	27,625,751.72	1,056,100.94
2.1.1.5	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.6	Хүүний өглөг	3,769,532,660.97	4,005,442,518.67
2.1.1.7	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	47,699,555.00	58,147,269.83
2.1.1.9	Нөөц (өр төлбөр)	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	85,243,245.46	4,962,788,317.23

2.1.1.11	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн бус хөрөнгө (борлуулах бүлэг хөрөнгө)-нд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.12			
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	8,298,756,925.62	12,627,004,911.92
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.1	Урт хугацаат зээл	35,737,455,975.82	36,279,370,411.44
2.1.2.2	Нөөц (өр төлбөр)	0.00	0.00
2.1.2.3	Хойшлогдсон татварын өр	0.00	280,944,103.28
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр	35,000,000.00	35,000,000.00
2.1.2.5			
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн	35,772,455,975.82	36,595,314,514.72
2.2	Өр төлбөрийн нийт дүн	44,071,212,901.44	49,222,319,426.64
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: - төрийн	53,761,631,549.95	54,067,984,610.95
2.3.2	- хувийн	0.00	0.00
2.3.3	- хувьцаат	0.00	0.00
2.3.4	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	5,763,630,095.45	5,763,630,095.45
2.3.7	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг	2,058,278,000.00	3,303,386,744.82
2.3.9	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	(21,986,825,524.44)	(28,137,074,608.23)
2.3.10			
2.3.11	Эздийн өмчийн дүн	39,596,714,120.96	34,997,926,842.99
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	83,667,927,022.40	84,220,246,269.63

4.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12 дугаар сарын 31	2019 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	19,298,241,108.67	23,460,431,423.28
2	Борлуулалтын өртөг	27,417,052,282.85	31,688,947,943.87
3	Нийт ашиг (алдагдал)	(8,118,811,174.18)	(8,228,516,520.59)
4	Түрээсийн орлого	0.00	0.00
5	Хүүний орлого	21,255,293.12	19,390,228.35
6	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
7	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
8	Бусад орлого	8,497,987,465.40	8,033,711,854.61
9	Борлуулалт, маркетингийн зардал	(2,478,642,508.23)	(2,685,902,169.22)
10	Ерөнхий ба удирдлагын зардал	(2,059,140,527.63)	(2,211,180,746.50)
11	Санхүүгийн зардал	(307,148,893.50)	(235,909,857.70)
12	Бусад зардал	(250,360,326.78)	(178,862,702.66)
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	(163,753,716.78)	(92,717,001.33)
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	3,200,000.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	(239,023,148.74)	(287,379,042.71)
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(5,094,437,537.32)	(5,867,365,957.75)
19	Орлогын татварын зардал	(2,125,529.30)	(300,055,959.07)
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(5,096,563,066.62)	(6,167,421,916.82)
21	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(5,096,563,066.62)	(6,167,421,916.82)
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	(5,096,563,066.62)	(6,167,421,916.82)
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2018 оны 12 дугаар сарын 31	2019 оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	20,611,854,339.37	27,923,134,570.96
	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	11,065,726,399.62	17,340,912,392.82
	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	64,365,441.32	1,089,942,359.60
	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	11,042,845.00	58,387,549.07
	Буцаан авсан албан татвар	0.00	2,285,791.00
	Татаас, санхүүжилтийн орлого	8,599,966,600.00	8,600,000,000.00
	Бусад мөнгөн орлого	870,753,053.43	831,606,478.47
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(20,416,520,815.38)	(26,614,893,564.89)
	Ажиллагчдад төлсөн	(4,472,767,505.91)	(4,143,282,590.94)
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	(1,126,959,634.49)	(1,248,057,477.26)
	Бараа материал худалдан авахад төлсөн	(8,778,612,475.85)	(10,368,047,995.59)
	Ашиглалтын зардалд төлсөн	(1,420,741,490.21)	(3,954,073,173.38)
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	(305,298,392.77)	(304,450,341.99)
	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
	Татварын байгууллагад төлсөн	(2,496,436,888.74)	(4,278,740,687.79)
	Даатгалын төлбөрт төлсөн	(8,982,637.00)	(20,331,818.96)
	Бусад мөнгөн зарлага	(1,806,721,790.42)	(2,297,909,478.98)
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	195,333,523.99	1,308,241,006.07
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	24,943,185.96	22,678,440.44
	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	11,137,500.00	490,909.09
	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	0.00	1,800,000.00
	Хүлээн авсан хүүний орлого	13,805,685.96	20,387,531.35
	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
			0.00
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	(856,751,390.00)	(1,407,366,823.28)
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(749,026,440.00)	(1,050,826,465.28)
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	(54,620,550.00)	(341,533,358.00)
	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	(53,099,400.00)	(15,007,000.00)
	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	(5,000.00)	0.00
			0.00
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-831,808,204.04	(1,384,688,382.84)

3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		0.00
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
	Хувьцаа болон өмчийн бусад үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	0.00	0.00
	Төрөл бүрийн хандив	0.00	0.00
			0.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	0.00
	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
	Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн	0.00	0.00
	Төлсөн ногдол ашиг	0.00	0.00
			0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00
4.1	Валютын ханшийн зөрүү	98,278.06	(320,636.77)
4.2	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(636,376,401.99)	(76,768,013.54)
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,023,093,640.65	386,717,238.66
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	386,717,238.66	309,949,225.12

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	Нийт дүн
2017 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	52,779,560,590.07	1,658,485,129.60	476,793,182.10	(13,734,409,107.26)	41,180,429,794.51
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	(3,155,853,350.51)	(3,155,853,350.51)
Залруулсан үлдэгдэл	52,779,560,590.07	1,658,485,129.60	476,793,182.10	(16,890,262,457.77)	38,024,576,444.00
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(5,096,563,066.66)	(5,096,563,066.66)
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	982,070,959.88	0.00	1,581,484,817.90	0.00	2,563,555,777.78
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	4,105,144,965.85	0.00	0.00	4,105,144,965.85
2018 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	53,761,631,549.95	5,763,630,095.45	2,058,278,000.00	(21,986,825,524.44)	39,596,714,120.96
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00	17,172,833.03	17,172,833.03
Залруулсан үлдэгдэл	53,761,631,549.95	5,763,630,095.45	2,058,278,000.00	(21,969,652,691.41)	39,613,886,953.99
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	0.00	0.00	(6,167,421,916.82)	(6,167,421,916.82)
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00	0.00	0.00
Өмчид гарсан өөрчлөлт	306,353,061.00	0.00	1,245,108,744.82	0.00	1,551,461,805.82
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00	0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00	0.00	0.00
2019 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	54,067,984,610.95	5,763,630,095.45	3,303,386,744.82	(28,137,074,608.23)	34,997,926,842.99

4.5 Зорилтот түвшин, гүйцэтгэл

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Худалдаж авсан ЦЭХ-ний зардал	16,076.53	22,444.49	(6,367.96)	140%
Шатахууны зардал	118.45	117.23	1.22	99%
Сэлбэг хэрэгсэл	332.45	271.20	61.24	82%
Урсгал засвар	199.12	195.47	3.65	98%
Үндсэн ба нэмэгдэл цалин, урамшуулал	4,599.83	4,556.90	42.94	99%
Байгууллагаас төлөх ЭМ, НДШ	620.98	638.55	(17.57)	103%
Ашиглалтын зардал-Цахилгаан	48.13	47.04	1.08	98%
Ашиглалтын зардал-Дулаан	127.80	127.15	0.65	99%
Ашиглалтын зардал-Ус	65.22	33.85	31.36	52%
Албан томилолтын зардал	81.44	80.62	0.82	99%
Контор хангамж / Бичиг хэрэг /	27.94	27.63	0.31	99%
Харилцаа холбооны зардал	34.71	34.65	0.06	100%
Тээврийн зардал	13.96	7.06	6.90	51%
Хеделмер хамгааллын зардал	326.77	326.31	0.45	100%
Гамшгаас хамгаалах зардал	52.17	41.94	10.23	80%
Гүйцэтгэх удирдлагын зардал	450.01	439.20	10.81	98%
Төлөөлөн удирдах зөвлөлийн зардал	58.80	53.81	4.99	92%
Зээлийн хүүгийн зардал	-	244.49	(244.49)	100%
Борлуулалт, маркетингийн зардал	13.76	13.67	0.10	99%
Диспетчерийн зардал / түгээх үйлчилгээний хөлс	1,984.97	2,310.90	(325.94)	116%
Зохицуулалтын үйлчилгээний хөлс	38.85	45.71	(6.86)	118%
Гадны үйлчилгээний хөлс	103.81	93.74	10.07	90%
Сургалтын зардал	30.30	30.30	-	100%
Найдваргүй авлагын зардал	-	14.10	(14.10)	100%
Үйл ажиллагааны бусад зардал	135.15	421.58	(286.43)	312%
Үйл ажиллагааны зардал	25,541.15	32,617.60	(7,076.45)	128%
Ерөнхий хэрэглээний үндсэн хөрөнгийн элэгдэлийн зардал	3,467.55	3,606.76	(139.22)	104%
Элэгдлийн зардлын дүн	3,467.55	3,606.76	(139.22)	104%
Үл хөдлөх хөрөнгийн татвар	130.96	40.61	90.35	31%
АТӨЯХ-ийн албан татвар	5.01	5.90	(0.90)	118%
Газрын телбер	13.33	14.90	(1.57)	112%
Бусад татвар хураамж	-	382.23	(382.23)	100%
Орлогын албан татвараас бусад татвар	149.30	443.64	(294.35)	297%
Ажиллагсдын нийгмийн зардал	919.34	873.61	45.73	95%
ХО-ын өгөөжөөр нөхөгдөх зардлын дүн	919.34	873.61	45.73	95%
Валютын ханшны алдагдал	-	92.77	(92.77)	100%
ҮА-ны бус бусад зардал	-	46.57	(46.57)	100%
Нийт зардал /29+32+37+40/	30,077.33	37,680.96	(7,603.63)	125%
Борлуулалтын орлого	16,106.55	23,460.42	(7,353.87)	146%
Санхүүжилт	7,818.18	7,818.18	0.00	100%
Бусад орлого	251.69	234.93	16.76	93%
Нийт орлого	24,176.42	31,513.53	(7,337.11)	130%
Татварын дараахи ашиг/алдагдал	(5,900.91)	(6,167.42)	266.51	105%

5.Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.03.14	Аудитын нэр: “Баруун бүсийн эрчим хүчний систем” ТӨХК 2019 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайланд хийсэн. санхүүгийн тайлангийн аудит	Аудитын код: САГ-2020/29/СТА-ТӨҮГ
Шалгагдсан байгууллагын нэр: Баруун бүсийн эрчим хүчний систем ТӨХК	Сая төгрөгөөр	

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгуул агаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	"Эрчим хүчний хөгжлийн төв" ТӨҮГ-т төлөх 35.0 сая төгрөг, "Бөх мөрөн сумын хийн цахилгаан станц" ХХК-д төлөх 3.1 сая төгрөг, Шинэ нисэх буудлын "Ашиглалтын өмнөх захиргаа"-д төлөх 1.5 сая төгрөгийн өр төлбөр бүртгэлтэй байна. Эдгээр нь 2004-2009 онд үүссэн боловч одоог хүртэл төлж барагдуулаагүй, төлөх эсэх нь тодорхойгүй, тооцоо нийлээгүй байгаа нь "эрх ба үүрэг" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71 дүгээр зүйлийн 8-д "өр, авлагыг барагдуулах арга хэмжээ авч үлдэгдлийг тооцож байх" гэсэн заалттай нийцэхгүй байна.	39.6	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал	Р.Нямтуул
2	Ажилчдад олгосон нүүрсний хөнгөлөлт болон нэг удаагийн шинжтэй тэтгэмж 33.5 сая төгрөгийг борлуулсан бүтээгдэхүүний өртөг шингээсэн нь "толилуулга ба тодруулга" гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүйгээс гадна Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 2.6.9-д "өртөг, зардлын бүртгэлийн бодлого"-ыг мөрдөж ажиллаагүй байна.	33.5	Зөвлөмж өгөх	Гүйцэтгэх захирал	Р.Нямтуул
	Дүн	73.1			

